



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 336.

Улаанбаатар хот

Г Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр  
гадаадад сургах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтооюор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Буяагийн Тултыг АНУ-ын Колумбын их сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Ганбатын Батчимэгийг АНУ-ын Лос-Анжелес хотын Калифорни хотын улсын их сургуулийн магистрантурт боловсрол судлалын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Гадаад харилцааны яамны захиалгаар Ганжуурыйн Мэнхсайхныг ОХУ-ын Дипломатын Академид 3 жилийн хугацаагаар, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Ганболдын Энхтайвныг ОХУ-ын М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуульд хуулийн чиглэлээр 3 жилийн хугацаагаар, Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газрын захиалгаар Гоодийзийн Батболдыг АНУ-ын Галлаудетын их сургуулийн хэлний бэлтгэлд 1 жилийн хугацаагаар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар Дашдондогийн Бат-Эрдэнийг АНУ-ын Жорж Мейсоны их сургуульд төрийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Онцгой байдлын ерөнхий газрын захиалгаар Санжаагийн Нэмэхбаярыг ОХУ-ын Гал эсэргүүцэх албаны Академид 3 жилийн хугацаагаар 2009-2010 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр тус тус суралцуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтооюор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

Е.ОТГОНБАЯР